



Орлогон түүхийн хэвлэл
ны 10 дугаар сарын 13
№38 /659/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
лон улсын гэрээ

**Барааны тэмдгийн хуулийн
тухай Сингапурын гэрээ**

1553

Монгол Улсын
рөнхийлөгчийн
зарлиг

**Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай**

1579

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

**Хуурамч эмтэй тэмцэх
үндэсний стратегийн тухай**

1580

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

323. Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээ 1553

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

324. Элчин сайдыг эгүүлэн татах,
томилдох тухай Дугаар 186 1579

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

325. Хуурамч эмтэй тэмцэх үндэсний
стратегийн тухай Дугаар 153 1580
326. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай Дугаар 157 1580
327. Хувиргасан амьд организмг нэвтрүүлэх
хилийн боомтын тухай Дугаар 158 1581
328. Тогтоол хүчингүй болсонд тооцох
тухай Дугаар 160 1582
329. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай Дугаар 161 1582
330. Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн
зохицуулалтыг сайжруулах тухай Дугаар 162 1583

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**БАРААНЫ ТЭМДГИЙН ХУУЛИЙН ТУХАЙ
СИНГАПУРЫН ГЭРЭЭ*****Гэрээний зүйлүүд**

- 1 дүгээр зүйл: Төвчилсон илэрхийллүүд
2 дугаар зүйл: Гэрээг хэрэглэх тэмдгүүд
3 дугаар зүйл: Мэдүүлэг
4 дүгээр зүйл: Төлөөлөл, харилцах хаяг

* Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээнд нэгдэн орох тухай хууль
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 25 (646) дугаарт нийтлэгдсэн.



- 5 дугаар зүйл: Анхдагч огноо
- 6 дугаар зүйл: Бараа, үйлчилгээний хэд хэдэн ангид хамаарах нэг бүртгэл
- 7 дугаар зүйл: Мэдүүлэг, бүртгэлийг салгах
- 8 дугаар зүйл: Мэдээлэл харилцаа
- 9 дүгээр зүйл: Бараа, үйлчилгээний ангилал
- 10 дугаар зүйл: Нэр, хаягийн өөрчлөлт
- 11 дүгээр зүйл: Эзэмшигчийн өөрчлөлт
- 12 дугаар зүйл: Алдааг залруулах
- 13 дугаар зүйл: Бүртгэлийн хүчинтэй байх хугацаа ба түүнийг сунгах
- 14 дүгээр зүйл: Хугацаа баримтлах шаардлагыг хангаагүй тохиолдолд үзүүлэх хөнгөлөлт
- 15 дугаар зүйл: Парисын конвенцийг дагаж мөрдөх үүрэг
- 16 дугаар зүйл: Үйлчилгээний тэмдэг
- 17 дугаар зүйл: Лиценз бүртгүүлэх тухай хүсэлт
- 18 дугаар зүйл: Лицензийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгуулах тухай хүсэлт
- 19 дүгээр зүйл: Лицензийг бүртгүүлээгүйгээс үүсэн гарах үр дагавар
- 20 дугаар зүйл: Лицензийн талаарх заалт
- 21 дүгээр зүйл: Татгалзах тохиолдолд гаргах тайлбар
- 22 дугаар зүйл: Журам
- 23 дугаар зүйл: Чуулган
- 24 дүгээр зүйл: Олон улсын товчоо
- 25 дугаар зүйл: Засвар оруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах
- 26 дугаар зүйл: Гэрээнд оролцогч Тал болох
- 27 дугаар зүйл: 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээ ба энэхүү Гэрээг хэрэглэх
- 28 дугаар зүйл: Хүчин төгөлдөр болох; Соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичиг хүчинтэй болох огноо
- 29 дүгээр зүйл: Тайлбар
- 30 дугаар зүйл: Гэрээг цуцлах
- 31 дүгээр зүйл: Гэрээний хэл; Гарын үсэг зурах
- 32 дугаар зүйл: Эх хадгалагч

1 дүгээр зүйл

Товчилсон илэрхийллүүд

Энэхүү Гэрээний зорилгоор тусгайлан өөрөөр заагаагүй бол:

(i) "Алба" гэж Хэлэлцэн тохирогч талын тэмдэг бүртгэх эрх бүхий байгууллагыг;

(ii) "бүртгэл" гэж Албанд хийгдэх тэмдгийн бүртгэлийг;

(iii) "мэдүүлэг" гэж бүртгүүлэх тухай мэдүүлгийг;

(iv) "мэдээлэл" гэж Албанд гаргасан аливаа мэдүүлэг, мэдүүлэг эсхүл бүртгэлд хамаарах аливаа хүсэлт, мэдэгдэл, захидал буюу бусад



мэдээллийг;

(v) "этгээд" гэдэгт хувь хүн, хуулийн этгээд аль алинийг нь ;

(vi) "эзэмшигч" гэж тэмдгийн бүртгэлд эзэмшигч гэж заасан этгээдийг;

(vii) "тэмдгийн бүртгэл" гэж хадгалагдаж буй хэлбэрээс үл хамааран нийт бүртгэлийн агуулга ба нийт бүртгэлд хамаарах бүртгэгдсэн нийт мэдээллийг агуулах Албаны бүрдүүлсэн мэдээллийн цогцыг;

(viii) "Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагаа" гэж мэдүүлэг, бүртгэлтэй холбоотой Албаны ажиллагаанд хамаарах аливаа үйл ажиллагааг;

(ix) "Парисын конвенци" гэж 1883 оны 3-р сарын 20-ны өдөр байгуулсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийг;

(x) "Ниццийн ангилал" гэж 1957 оны 6-р сарын 15-нд байгуулсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан Тэмдгийг бүртгэх зорилгоор ашиглах бараа, үйлчилгээний Олон улсын ангиллын тухай Ниццийн хэлэлцээрээр баталсан ангиллыг;

(xi) "лиценз" гэж Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу тэмдгийг ашиглах лицензийг;

(xii) "лиценз авагч" гэж лиценз олгогдсон этгээдийг;

(xiii) "Хэлэлцэн тохирогч тал" гэж энэхүү Гэрээнд оролцогч аливаа Улс болон Засгийн газар хоорондын байгууллагыг;

(xiv) "Дипломат бага хурал" гэж энэхүү Гэрээнд засвар оруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор зарлагдсан Хэлэлцэн тохирогч талуудын хуралдаан;

(xv) "Чуулган" гэж 23 дугаар зүйлд заасан Чуулганыг;

(xvi) "Соёрхон баталсан тухай баримт бичиг" гэдэгт хүлээн зөвшөөрсөн болон баталсан тухай баримт бичгийг хамруулан;

(xvii) "Байгууллага" гэж Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагыг;

(xviii) "Олон улсын Товчоо" гэж Байгууллагын Олон улсын Товчоог;

(xix) "Ерөнхий захирал" гэж Байгууллагын Ерөнхий захирлыг;

(xx) "Журам" гэж 22 дугаар зүйлд заасан энэхүү Гэрээний журмыг;

(xxi) "Зүйл" эсхүл зүйлийн "хэсэг", "дэд хэсэг" гэдэгт Журмын холбогдох дүрмүүдэд заасныг хамруулан;

(xxii) "1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай гэрээ" гэж Женевт 1994 оны 10-р сарын 27-нд байгуулсан Барааны тэмдгийн хуулийн тухай гэрээг тус тус ойлгоно.

2 дугаар зүйл

Гэрээг хэрэглэх тэмдгүүд

(1) [Тэмдгийн шөж тэмдэг] Хэлэлцэн тохирогч аливаа тал өөрийн хууль тогтоомжийн дагуу бүртгэгдэж болох илэрхийллээс бүрдсэн барааны



тэмдэгт энэхүү Гэрээг хэрэглэнэ.

(2) [Тэмдгийн төрлүүд]

(а) Энэхүү Гэрээг бараанд (барааны тэмдэг) эсхүл үйлчилгээнд (үйлчилгээний тэмдэг) эсхүл бараа, үйлчилгээний аль алинд нь хамаарах тэмдэгт хэрэглэнэ.

(б) Энэхүү Гэрээг хамтын, гэрчлэх болон баталгааны тэмдэгт хэрэглэхгүй.

3 дугаар зүйл

Мэдүүлэг

(1) [Мэдүүлэгт агуулагдах буюу мэдүүлгийг дагалдах заалт эсхүл бүрдэл хэсэг, Хураамж]

(а) Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэгт дараахь заалт эсхүл бүрдэл хэсгийн зарим эсхүл бүгдийг агуулсан байхыг шаардаж болно:

(i) бүртгүүлэх тухай хүсэлт;

(ii) мэдүүлэг гаргагчийн нэр, хаяг;

(iii) мэдүүлэг гаргагч нь аль нэг Улсын иргэн бол тухайн Улсын нэр; мэдүүлэг гаргагч нь аль нэг Улсад оршин суудаг бол тэр Улсын нэр; мэдүүлэг гаргагч нь аль нэг Улсын нутаг дэвсгэрт бодитойгоор, хууль ёсны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг бол тэр Улсын нэр;

(iv) мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний эрх зүйн байдал ба Улсын нэр; шаардлагатай бол тухайн хуулийн этгээд хууль тогтоомжийнх нь дагуу үүсгэн байгуулагдсан улсын засаг захиргааны нэгжийн нэр;

(v) мэдүүлэг гаргагч нь төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(vi) хэрэв 4(2)(b) дүгээр зүйлд заасны дагуу шаардлагатай бол харилцах хаяг;

(vii) мэдүүлэг гаргагч нь өмнө гаргасан мэдүүлэгт үндэслэн давамгайлах эрх эдлэхийг хүсвэл Парисын конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу шаардагдаж болох заалт болон нотолгоо бүхий давамгайлах эрх хүссэн мэдэгдэл;

(viii) мэдүүлэг гаргагч нь бараа ба/эсхүл үйлчилгээг үзэсгэлэнд дэлгэн үзүүлснээс үүсэх хамгаалалтын давуу эрх эдлэхийг хүсвэл Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу шаардагдах заалт бүхий мэдэгдэл;

(ix) Журмаар тогтоосны дагуу доод тал нь тэмдгийн нэг дүрслэл;

(x) шаардлагатай бол Журмаар тогтоосны дагуу тэмдгийн төрөл болон тухайн тэмдгийн төрөлд тавигдах тусгай шаардлагыг заасан мэдэгдэл;

(xi) шаардлагатай бол Журмаар тогтоосны дагуу мэдүүлэг гаргагч нь тэмдгийг Албанд хэрэглэгддэг стандарт тэмдэглэгээг ашиглан



бүртгүүлэх болон хэвлүүлэхийг хүссэн мэдэгдэл;

(xii) шаардлагатай бол Журмаар тогтоосны дагуу мэдүүлэг гаргагч нь тэмдгийн ялгагдах онцгой шинж чанарын хувьд өнгийн хамгаалалтыг хүсвэл энэ тухай заасан мэдэгдэл;

(xiii) тэмдгийн эсхүл түүний зарим хэсгийн галигласан хөрвүүлэг;

(xiv) тэмдгийн эсхүл түүний зарим хэсгийн орчуулга;

(xv) бүртгүүлэх барааны тэмдэгт хамаарах Ниццийн ангиллын дагуу ангилсан бараа ба/эсхүл үйлчилгээний нэрс. Ингэхдээ дурдсан Ангиллын дарааллын дагуу жагсаасан бүлэг бүрийн өмнө холбогдох ангийн дугаарыг заана;

(xvi) Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор шаарддаг бол тэмдгийг ашиглахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдэл.

(b) мэдүүлэг гаргагч нь (a)(xvi) дэд хэсэгт заасан тэмдгийг ашиглахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлийн оронд буюу түүнд нэмэлт болгож тэмдгийг бодитойгоор хэрэглэж байгаа тухай нотолгоо бүхий мэдэгдлийг Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн шаардлагын дагуу гаргаж болно.

(c) Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэгт хамаарах хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно.

(2) [Бараа, үйлчилгээний хэд хэдэн ангид хамаарах нэг мэдүүлэг] Ниццийн ангиллын нэг буюу хэд хэдэн ангид харьяалагдахаас үл хамааран нэг мэдүүлэг хэд хэдэн бараа, үйлчилгээнд хамаарч болно.

(3) [Бодит ашиглалт] (1)(a)(xvi) хэсэгт заасны дагуу тэмдгийг ашиглахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдэл гаргасан бол аливаа Хэлэлцэн тохирогч тал нь өөрийн хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд тэмдгийг бодитойгоор ашиглаж байгаа тухай нотолгоог Албанд гаргаж өгөхийг мэдүүлэг гаргагчаас шаардаж болно. Дээрх хугацаа нь Журмаар тогтоосон хамгийн бага хугацаанд нийцсэн байна.

(4) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэгтэй холбоотойгоор (1), (3) дугаар заалт болон 8 дугаар зүйлд зааснаас бусад зүйлийг шаардаж болохгүй. Тухалбал, мэдүүлэгтэй холбоотой шийдвэр гарах хүртлэх хугацаанд дараахь зүйлийг шаардахгүй. Үүнд:

(i) аливаа бүртгэлийн гэрчилгээ эсхүл бүртгэлийн газрын лавлагаа гаргаж өгөхийг;

(ii) мэдүүлэг гаргагч нь үйлдвэрлэл эсхүл худалдааны үйл ажиллагаа явуулдаг тухай мэдээлэл болон холбогдох нотолгоо гаргаж өгөхийг;

(iii) мэдүүлэг гаргагч нь мэдүүлэгт дурдсан бараа, үйлчилгээтэй хамааралтай үйл ажиллагаа явуулдаг тухай мэдээлэл болон түүнд холбогдох нотолгоо гаргаж өгөхийг;



(iv) мэдүүлэг гаргагч нь Парисын конвенцийн *quinquies* зүйлийг хэрэглэхийг хүссэнээс бусад тохиолдолд тухайн тэмдэг нь Хэлэлцэн тохирогч өөр талын эсхүл Хэлэлцэн тохирогч тал бус Парисын конвенцийн оролцогч Улсын тэмдгийн бүртгэлд бүртгэгдсэн тухай нотолгоо гаргаж өгөхийг.

(5) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэгт агуулагдсан аливаа мэдээлэл эсхүл бүрдэл хэсгийн үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл мэдүүлгийн шүүлтийн явцад Албанд нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

4 дүгээр зүйл

Төлөөлөл; Харилцах хаяг

(1) [Үйл ажиллагаа явуулахаар хүлээн зөвшөөрөгдсөн төлөөлөгч]

(a) Хэлэлцэн тохирогч аливаа тал Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагааг гүйцэтгэх зорилгоор томилогдсон төлөөлөгч дараахь нөхцөлийг хангасан байхыг шаардаж болно. Үүнд:

(i) холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдүүлэг болон бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг явуулах, шаардлагатай бол Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй байх;

(ii) өөрийн хаягийн хувьд Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр дээрх хаягийг заах .

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу Хэлэлцэн тохирогч талын тавих шаардлагад нийцсэн төлөөлөгчийн эсхүл түүнд хандсан Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагаатай холбоотой үйлдлийг тухайн төлөөлөгчийг томилсон мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээдийн хийсэн үйлдэл гэж үзнэ.

(2) [Зайлшгүй байх төлөөлөл; Харилцах хаяг]

(a) Хэлэлцэн тохирогч аливаа тал өөрийн нутаг дэвсгэрт оршин суудаггүй эсхүл бодитойгоор, хууль ёсны үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэггүй мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээдээс Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагааг явуулах зорилгоор төлөөлөгчөөр төлөөлүүлсэн байхыг шаардаж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу төлөөлөгчөөр зайлшгүй төлөөлүүлэхийг шаарддаггүй бол Хэлэлцэн тохирогч аливаа тал өөрийн нутаг дэвсгэрт оршин суудаггүй эсхүл бодитойгоор, хууль ёсны үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэггүй мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээдээс Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагаа явуулах зорилгоор тухайн нутаг дэвсгэрт харилцах хаягтай байхыг шаардаж болно.



(3) [Итгэмжлэл]

(а) Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл аливаа сонирхогч этгээд түүний Албанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн байхыг зөвшөөрдөг эсхүл шаарддаг тохиолдолд тухайн төлөөлөгч нь мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад этгээдийн нэрийг заасан тусгай мэдэгдлээр (цаашид "итгэмжлэл" гэх) томилогдсон байхыг шаардаж болно.

(б) Итгэмжлэл нь түүнд заагдсан нэг эсхүл хэд хэдэн мэдүүлэг буюу бүртгэлд эсхүл төлөөлөгчийг томилсон этгээд өөрөөр заагаагүй бол тухайн этгээдийн одоогийн болон цаашдын бүх мэдүүлэг буюу бүртгэлд хамаарч болно.

(с) Итгэмжлэл нь төлөөлөгчийн бүрэн эрхийг зарим үйлдлийн хувьд хязгаарлаж болно. Төлөөлөгчид мэдүүлгийг татаж авах эсхүл тэмдгийн бүртгэлээс татгалзах эрх олгосон итгэмжлэлийн хувьд Хэлэлцэн тохирогч аливаа тал энэ тухай итгэмжлэлд тусгайлан заасан байхыг шаардаж болно.

(д) Мэдээлэлд өөрийгөө төлөөлөгч гэж заасан этгээд тухайн мэдээллийг Албанд хүргүүлэх үед буюу Алба нь тухайн мэдээллийг хүлээж авах үед шаардлагатай итгэмжлэлийг аваагүй байгаа тохиолдолд Хэлэлцэн тохирогч тал Журамд заасан хамгийн бага хугацаанд нийцүүлэн тогтоосон хугацаанд итгэмжлэлийг ирүүлэхийг шаардаж болно. Хэлэлцэн тохирогч талын тогтоосон хугацаанд итгэмжлэл ирүүлээгүй бол тухайн мэдээллийг хүчингүйд тооцохоор зааж болно.

(4) [Итгэмжлэлийг иш татах]

Хэлэлцэн тохирогч аливаа тал төлөөлөгчөөс Албаны ажиллагаанд хамарах үйл ажиллагаа явуулах зорилгоор ирүүлсэн аливаа мэдээлэлд итгэмжлэгдсэн төлөөлөгч үйл ажиллагаагаа үндэслэн явуулж буй итгэмжлэлийг иш татсан байхыг шаардаж болно.

(5) [Бусад шаардлагуудыг хориглох]

Хэлэлцэн тохирогч аливаа тал (3), (4) дүгээр заалт болон 8 дугаар зүйлд заасан асуудлын хувьд тэдгээрт зааснаас өөр зүйл шаардахгүй.

(6) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч аливаа тал (3), (4) дүгээр заалтад заасан аливаа мэдээлэлд агуулагдсан заалтын үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

*5 дугаар зүйл
Анхдагч огноо*

(1) [Зөвшөөрөгдөх шаардлагууд]

(а) (b) дэд хэсэг болон (2) дугаар заалтад заасныг харгалзан Хэлэлцэн тохирогч тал нь мэдүүлгийн анхдагч огноог заалт



болон бүрдэл хэсгийг Алба хүлээн авсан өдрөөр тогтооно. Дээрх заалт болон бүрдэл хэсэгт дараахь зүйлүүд орох бөгөөд эдгээрийг 8(2) дугаар зүйлд заасан хэлээр үйлдэнэ:

(i) Тэмдэг бүртгүүлэхийг хүссэн тухай илэрхий буюу илэрхий бус заалт;

(ii) Мэдүүлэг гаргагчийг тодорхойлох боломж бүхий заалт;

(iii) Алба нь мэдүүлэг гаргагч эсхүл хэрэв байгаа бол түүний төлөөлөгчтэй харилцах боломж бүхий заалт;

(iv) Бүртгүүлэхийг хүсч буй тэмдгийн хангалттай тод дүрслэл;

(v) Бүртгүүлэхийг хүсч буй бараа, үйлчилгээний жагсаалт;

(vi) 3(1)(a)(xvi) дугаар зүйл эсхүл (b) хэсэг хамаарах бол Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай 3(1)(a)(xvi) дугаар зүйлд заасан мэдэгдэл эсхүл 3(1)(b) дугаар зүйлд заасан мэдэгдэл болон нотолгоо.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа тал анхдагч огноог (a) дэд хэсэгт заасан заалт болон бүрдэл хэсгийн бүгдийг бус заримыг нь эсхүл тэдгээрийг 8(2) дугаар зүйлд зааснаас өөр хэлээр үйлдсэнийг Алба хүлээн авсан огноогоор тогтоож болно.

(2) [Зөвшөөрөгдөх нэмэлт шаардлага]

(a) Хэлэлцэн тохирогч тал шаардлагатай хураамж төлөгдөх хүртэл анхдагч огноог тогтоохгүй байхаар зааж болно.

(b) Хэлэлцэн тохирогч тал (a) дэд хэсэгт заасан шаардлагыг зөвхөн тухайн Тал энэхүү Гэрээнд нэгдэж орох үед тавьж байсан тохиолдолд хэрэглэж болно.

(3) [Залруулга ба хугацаа] (1), (2) дугаар заалтад заасан залруулга хийх нөхцөл болон хугацааг Журмаар тогтооно.

(4) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлгийн анхдагч огнооны хувьд (1), (2) дугаар хэсэгт зааснаас өөр зүйл шаардахгүй.

6 дугаар зүйл

Бараа, үйлчилгээний хэд хэдэн ангид хамаарах нэг бүртгэл

Нэг мэдүүлэгт Ниццийн ангиллын хэд хэдэн ангид хамаарах бараа, үйлчилгээг хамааруулсан бол энэ мэдүүлгийн дагуу нэг бүртгэл хийгдэнэ.

7 дугаар зүйл

Мэдүүлэг, бүртгэлийг салгах

(1) [Мэдүүлгийг салгах]

(a) Хэд хэдэн бараа, үйлчилгээг заасан аливаа мэдүүлгийг

(цаашид "анхны мэдүүлэг" гэх):

(i) наад зах нь тэмдгийг бүртгэх тухай Албаны шийдвэр гарах хүртэл;

(ii) Тэмдгийг бүртгэх тухай Албаны шийдвэртэй холбоотой аливаа эсэргүүцлийг хянан хэлэлцэх ажиллагааны явцад;

(iii) Тэмдгийг бүртгэх эсэх талаар гарсан шийдвэртэй холбоотой аливаа давж заалдах өргөдлийг хянан хэлэлцэх ажиллагааны явцад, мэдүүлэг гаргагч эсхүл түүний хүсэлтээр анхны мэдүүлэгт заасан бараа, үйлчилгээг хуваарилах замаар хоёр эсхүл хэд хэдэн мэдүүлэг (цаашид "салгасан мэдүүлэг" гэх) болгон салгаж болно. Салгасан мэдүүлэг нь анхны мэдүүлгийн анхдагч огноо болон давамгайлах эрх байгаа тохиолдолд түүнийг хадгалж үлдэнэ.

(b) (a) дэд хэсгийг харгалзан Хэлэлцэн тохирогч аливаа тал хураамж төлөх зэрэг мэдүүлгийг салгахтай холбоотой шаардлагуудыг тогтоож болно.

(2) [Бүртгэлийг салгах] Бүртгэлийг салгахад (1) дүгээр заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ. Дараахь тохиолдолд бүртгэлийг салгахыг зөвшөөрнө:

(i) Бүртгэлийг хүчингүйд тооцуулах талаар гуравдагч этгээдээс Албанд гаргасан бүртгэлийг хүчингүйд тооцуулахтай холбоотой шаардлага бүхий аливаа үйл ажиллагааны явцад;

(ii) Албаны гаргасан өмнөх шийдвэртэй холбоотой аливаа давж заалдах өргөдлийг хянан хэлэлцэх ажиллагааны явцад.

Ингэхдээ Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомж нь тэмдэг бүртгэгдэх хүртэлх хугацаанд гуравдагч этгээд тухайн тэмдгийн бүртгэлийг эсэргүүцэхийг зөвшөөрдөг бол Хэлэлцэн тохиролцогч тал бүртгэлийг салгахгүй байхаар заасан эсэхийг харгалзан үзнэ.

8 дугаар зүйл Мэдээлэл харилцаа

(1) [Мэдээлэл дамжуулах хэрэгсэл ба хэлбэр] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдээлэл дамжуулах хэрэгсэл болон ийм мэдээг цаасан, цахим эсхүл бусад өөр хэлбэрээр хүлээн авах эсэхийг сонгож болно.

(2) [Мэдээллийг боловсруулах хэл]

(a) Хэлэлцэн тохирогч тал аливаа мэдээллийг өөрийн Албанд хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр боловсруулсан байхыг шаардаж болно. Алба нь нэгээс дээш хэлийг хүлээн зөвшөөрдөг бол мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээдийг Албанд хамаарах хэлний хувьд тавигдах бусад шаардлагыг хангахыг шаардаж болно. Ингэхдээ мэдээллийн заалт эсхүл түүний бүрдэл хэсгийг нэгээс дээш хэлээр үйлдэхийг шаардаж болохгүй.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү Гэрээнд зааснаас



өөрөөр мэдээллийн орчуулгыг гэрчлүүлсэн, нотариатаар гэрчлүүлсэн, жинхэнэ болохыг нотолсон, хууль зүйн хувьд баталгаажуулсан эсхүл бусад байдлаар гэрчлүүлсэн байхыг шаардаж болохгүй.

(с) Хэлэлцэн тохиролцогч тал мэдээллийг Албанд хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр боловсруулсан байхыг шаарддаггүй бол ийм мэдээллийг Албанд хүлээн зөвшөөрөгдсөн хэл рүү албан ёсны орчуулагч эсхүл төлөөлөгчөөр орчуулуулж зохих хугацаанд ирүүлэхийг шаардаж болно.

(3) [Цаасаар гаргасан мэдээллийн гарын үсэг]

(а) Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээд цаасаар гаргасан мэдээлэлдээ гарын үсэг зурсан байхыг шаардаж болно. Хэлэлцэн тохирогч тал нь цаасаар гаргасан мэдээлэлд гарын үсэг зурсан байхыг шаарддаг бол Журамд заасан шаардлагыг хангасан аливаа гарын үсгийг хүлээн зөвшөөрнө.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа талын хууль тогтоомжоор нь бүртгэлээс татгалзахтай холбоотойгоор гарын үсгийн баталгааг шаарддагаас бусад тохиолдолд аливаа гарын үсгийг гэрчлүүлсэн, нотариатаар гэрчлүүлсэн, жинхэнэ болохыг нотолсон, хууль зүйн хувьд баталгаажуулсан эсхүл бусад байдлаар гэрчлүүлсэн байхыг шаардахгүй.

(с) (b) дэд хэсгийг үл харгалзан цаасан хэлбэрээр гаргасан мэдээллийн гарын үсэг нь жинхэнэ гэдэгт Албаны зүгээс үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл түүнд нотолгоо гаргаж өгөхийг Хэлэлцэн тохирогч тал шаардаж болно.

(4) [Цахим хэлбэрээр эсхүл цахим хэрэгслээр дамжуулан гаргасан мэдээ] Хэлэлцэн тохирогч тал мэдээллийг цахим хэлбэрээр эсхүл цахим хэрэгслээр дамжуулан гаргахыг зөвшөөрдөг бол тэрээр аливаа ийм мэдээлэл нь Журамд заасан шаардлагад нийцсэн байхыг шаардаж болно.

(5) [Мэдээлэл гаргах] Хэлэлцэн тохирогч аливаа тал Журамд заасан Олон улсын Загвар Маягтын дагуу гаргасан мэдээллийг хүлээж авна.

(6) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал (1)-(5) дугаар заалтад заасантай холбоотойгоор энэхүү Зүйлд зааснаас бусад зүйл шаардахгүй.

(7) [Төлөөлөгчтэй харилцах] Энэхүү Зүйлээр мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээд ба тэдгээрийн төлөөлөгчийн хоорондоо хэрхэн харилцах талаарх асуудлыг зохицуулахгүй.



9 дүгээр зүйл

Бараа, үйлчилгээний ангилал

(1) [Бараа, үйлчилгээг заах] Мэдүүлэг эсхүл бүртгэлтэй холбоотой болон бараа, үйлчилгээний заалт агуулсан Албаны бүртгэл болон аливаа хэвлэлд тухайн бараа, үйлчилгээний Ниццийн ангиллын ангид дарааллын дагуу бүлэглэсэн нэрийг заана. Ингэхдээ анги бүрийн өмнө тухайн бараа, үйлчилгээний ангийн дугаарыг заана.

(2) [Нэг эсхүл өөр өөр ангид хамаарах бараа, үйлчилгээ]

(a) Албаны аливаа бүртгэл эсхүл хэвлэлд бараа, үйлчилгээ нь Ниццийн ангиллын нэг ангид хамаарч байна гэсэн үндэслэлээр уг бараа эсхүл үйлчилгээг хоорондоо төстэй гэж үзэж болохгүй.

(b) Албаны аливаа бүртгэл эсхүл хэвлэлд бараа, үйлчилгээ нь Ниццийн ангиллын өөр өөр ангид хамаарч байна гэсэн үндэслэлээр тухайн бараа эсхүл үйлчилгээг өөр хоорондоо ялгаатай гэж үзэж болохгүй.

10 дугаар зүйл

Нэр, хаягийн өөрчлөлт

(1) [Эзэмшигчийн нэр, хаягийн өөрчлөлт]

(a) Эзэмшигч этгээд хэвээрээ байгаа боловч түүний нэр ба/эсхүл хаягт өөрчлөлт орсон бол Хэлэлцэн тохирогч аливаа тал Албаны тэмдгийн бүртгэлд ийнхүү өөрчлөлт оруулахыг хүсч холбогдох бүртгэлийн дугаар болон бүртгэлд оруулах өөрчлөлтийг заасан эзэмшигчийн гаргасан хүсэлтийг хүлээн зөвшөөрнө.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа тал дараахь зүйлийг хүсэлтэд заасан байхыг шаардаж болно. Үүнд:

(i) Эзэмшигчийн нэр, хаяг;

(ii) Эзэмшигч төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(iii) Эзэмшигч харилцах хаягтай бол тухайн хаяг.

(c) Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлттэй холбоотой хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно.

(d) Тухайн өөрчлөлт нь хэд хэдэн бүртгэлд хамаарч байгаа ч хүсэлтэд холбогдох бүртгэлийн дугааруудыг бүгдийг заасан тохиолдолд нэг хүсэлт гаргахад хангалттай.

(2) [Мэдүүлэг гаргагчийн нэр эсхүл хаягийн өөрчлөлт] Мэдүүлэгт дугаар өгөөгүй эсхүл мэдүүлэг гаргагч эсхүл түүний төлөөлөгчид ийм дугаар мэдэгдэхгүй байгаа боловч Журамд заасны дагуу хүсэлт нь мэдүүлэгтэй адилтгагдаж байгаа тохиолдолд мэдүүлэг /мэдүүлгүүд/, эсхүл мэдүүлэг /мэдүүлгүүд/ болон бүртгэл /бүртгэлүүд/-д хамаарах өөрчлөлтөд (1) дүгээр заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ.



(3) [Төлөөлөгчийн нэр, хаяг эсхүл харилцах хаягийн өөрчлөлт] Төлөөлөгчтэй бол түүний нэр, хаягийн аливаа өөрчлөлт, мөн харилцах хаягтай бол түүний өөрчлөлтөд (1) дүгээр заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ.

(4) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал энэ зүйлд заасан хүсэлтийн хувьд (1)-(3) дугаар заалтууд болон 8 дугаар зүйлд зааснаас бусад шаардлагыг хангасан байхыг шаардаж болохгүй. Тухайлбал, өөрчлөлттэй холбоотой аливаа гэрчилгээ шаардахгүй.

(5) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлтэд агуулагдах аливаа заалтын үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

11 дүгээр зүйл Эзэмшигчийн өөрчлөлт

(1) [Бүртгэлийн эзэмшигч өөрчлөгдөх]

(а) Эзэмшигч этгээд өөрчлөгдсөн бол Хэлэлцэн тохирогч аливаа тал Албаны тэмдгийн бүртгэлд ийнхүү өөрчлөлт оруулахыг хүсч холбогдох бүртгэлийн дугаар болон бүртгэлд оруулах өөрчлөлтийг заасан эзэмшигч эсхүл эрх шилжүүлж авсан этгээдийн (цаашид "шинэ эзэмшигч" гэх) гаргасан хүсэлтийг хүлээн зөвшөөрнө.

(б) Гэрээ байгуулсны улмаас эзэмшигч өөрчлөгдсөн бол хүсэлт гаргахдаа энэ тухай заах бөгөөд хүсэлт гаргаж байгаа талын сонголтоор дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргахыг Хэлэлцэн тохирогч талаас шаардаж болно:

(i) Гэрээний хуулбар. Ингэхдээ хуулбар нь эх гэрээний хуулбар мөн болохыг нотариат эсхүл төрийн эрх бүхий бусад байгууллагаар гэрчлүүлсэн байхыг шаардаж болно;

(ii) Эзэмшигч өөрчлөгдөж байгааг заасан гэрээний нэг хэсэг. Ингэхдээ энэ нь эх гэрээний хэсэг мөн болохыг нотариат эсхүл төрийн эрх бүхий бусад байгууллагаар гэрчлүүлсэн байхыг шаардаж болно;

(iii) Журамд заасан маягт болон агуулгын дагуу үйлдэгдсэн бөгөөд эзэмшигч болон шинэ эзэмшигч гарын үсэг зурсан тэмдгийн эрхийг шилжүүлэх тухай гэрчлүүлэх шаардлагагүй тодорхойлолт;

(iv) Журамд заасан маягт болон агуулгын дагуу үйлдэгдсэн бөгөөд эзэмшигч болон шинэ эзэмшигч гарын үсэг зурсан тэмдгийн эрхийг шилжүүлэх тухай гэрчлүүлэх шаардлагагүй баримт бичиг;

(с) Нэгдсэний улмаас эзэмшигч өөрчлөгдсөн бол Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлтэд энэ тухай заах ба эрх бүхий байгууллагаас олгож нэгдсэнийг нотлох баримт бичгийн хуулбарыг хавсаргахыг шаардаж болно. Энэ нь бүртгэлийн байгууллагын лавлагааны хуулбар байж болох бөгөөд энэ хуулбар нь эх баримт бичгийн хуулбар мөн болохыг тухайн



баримт бичгийг олгосон байгууллага эсхүл нотариат, төрийн эрх бүхий бусад байгууллагаар гэрчлүүлсэн байхыг шаардаж болно.

(d) Бүх хамтран эзэмшигч биш нэг буюу хэд хэдэн хамтран эзэмшигч нь өөрчлөгдөх, энэ өөрчлөлт нь гэрээ байгуулснаас эхлэн нэгдсэний улмаас үүсч байвал Хэлэлцэн тохирогч аливаа тал өөрчлөлтөд хамрагдаагүй аливаа хамтран эзэмшигчээс ийм өөрчлөлт орохыг тусгайлан зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийг шаардаж болно.

(e) Гэрээ байгуулснаас эхлэн нэгдсэний улмаас бус хуулийн зохицуулалт, шүүхийн шийдвэрийн улмаас эзэмшигч өөрчлөгдвөл Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлтэд энэ тухай заах ба энэ өөрчлөлтийг нотолсон баримт бичгийн хуулбарыг хавсаргахыг шаардаж болно. Энэ хуулбар нь эх баримт бичгийн хуулбар мөн болохыг тухайн баримт бичгийг олгосон байгууллага эсхүл нотариат, төрийн эрх бүхий бусад байгууллагаар гэрчлүүлсэн байхыг шаардаж болно.

(f) Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлтэд дараахь зүйлийг заасан байхыг шаардаж болно:

(i) Эзэмшигчийн нэр, хаяг;

(ii) Шинэ эзэмшигчийн нэр, хаяг;

(iii) Шинэ эзэмшигч нь аль нэг Улсын иргэн бол тухайн Улсын нэр; шинэ эзэмшигч нь аль нэг Улсад оршин суудаг бол тэр Улсын нэр, шинэ эзэмшигч нь аль нэг Улсын нутаг дэвсгэрт бодитойгоор, хууль ёсны үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг бол тэр Улсын нэр;

(iv) Шинэ эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний эрх зүйн байдал, Улсын нэр; шаардлагатай бол тухайн хуулийн этгээд хууль тогтоомжийнх нь дагуу үүсгэн байгуулагдсан Улсын засаг захиргааны нэгжийн нэр;

(v) Эзэмшигч нь төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(vi) Эзэмшигч нь харилцах хаягтай бол түүнийг заах;

(vii) Шинэ эзэмшигч нь төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(viii) 4(2)(b) дүгээр зүйлд заасны дагуу шаардлагатай бол шинэ эзэмшигчийн харилцах хаягийг заах.

(g) Хэлэлцэн тохирогч аливаа тал хүсэлтэд хамаарах хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно.

(h) Эзэмшигчийн өөрчлөлт нь хэд хэдэн бүртгэлд хамаарч байгаа ч бүртгэл бүрийн хувьд эзэмшигч болон шинэ эзэмшигч нь ижил бол холбогдох бүртгэлийн дугааруудыг бүгдийг заасан тохиолдолд нэг хүсэлт гаргахад хангалттай.

(i) Хэрэв эзэмшигчийн өөрчлөлт нь эзэмшигчийн бүртгэлд орсон бүх бараа, үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд холбогдох хууль тогтоомжоор энэ өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрдөг бол Алба нь эзэмшигч нь өөрчлөгдсөн бараа, үйлчилгээнд хамаарах бүртгэлийг салгаж хийнэ.

(2) [Мэдүүлэг гаргагч өөрчлөгдөх] Мэдүүлэгт дугаар өгөөгүй эсхүл мэдүүлэг гаргагч эсхүл түүний төлөөлөгчид ийм дугаар мэдэгдэхгүй байгаа боловч Журамд заасны дагуу хүсэлт нь мэдүүлэгтэй адилтгагдаж байгаа



тохиолдолд мэдүүлэг /мэдүүлгүүд/, эсхүл мэдүүлэг /мэдүүлгүүд/ болон бүртгэл /бүртгэлүүд/-д хамаарах эзэмшигчийн өөрчлөлтөд (1) дүгээр заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ.

(3) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал энэ зүйлд заасан хүсэлтийн хувьд (1), (2) дугаар заалтууд болон 8 дугаар зүйлд зааснаас бусад шаардлагыг хангасан байхыг шаардаж болохгүй. Тухайлбал, дараахь нөхцөлийг биелүүлэхийг шаардаж болохгүй:

(i) (1)(с) заалтыг харгалзан аливаа гэрчилгээ эсхүл бүртгэлийн байгууллагын лавлагаа гаргаж өгөхийг;

(ii) Шинэ эзэмшигч нь үйлдвэрлэл эсхүл худалдааны үйл ажиллагаа явуулдаг тухай заах ба холбогдох нотолгоо гаргаж өгөхийг;

(iii) Шинэ эзэмшигч нь эзэмшигчийн өөрчлөлтөд хамрагдаж буй бараа, үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг тухай заах ба холбогдох нотолгоо гаргаж өгөхийг;

(iv) Эзэмшигч нь өөрийн аж ахуйн нэгж эсхүл холбогдох биет бус хөрөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шинэ эзэмшигчид шилжүүлснийг заах ба холбогдох нотолгоо гаргаж өгөхийг;

(4) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч Талууд энэ Зүйлд заасан хүсэлт эсхүл баримт бичигт агуулагдсан аливаа заалтын үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл нотолгоо, мөн (1)(с) эсхүл (е) хэсэгт хамаарах тохиолдолд нэмэлт нотолгоог Албанд гаргаж өгөхийг шаардаж болно.

*12 дугаар зүйл
Алдааг залруулах*

(1) [Бүртгэлд хамаарах алдааг залруулах]

(a) Хэлэлцэн тохирогч Талууд Албанд гаргасан мэдүүлэг болон бусад хүсэлтэд гаргасан алдаа нь Албаны тэмдгийн бүртгэл эсхүл түүнээс гаргасан аливаа хэвлэлд орсон тохиолдолд холбогдох бүртгэлийн дугаар, алдаа, бүртгэлд оруулах залруулга бүхий эзэмшигчээс гаргасан хүсэлтийг хүлээн авна.

(b) Хэлэлцэн тохирогч Талууд дараахь зүйлийг хүсэлтдээ заасан байхыг шаардаж болно. Үүнд:

(i) эзэмшигчийн нэр, хаяг;

(ii) эзэмшигч нь төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(iii) эзэмшигч нь харилцах хаягтай бол түүнийг;

(c) Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлттэй холбоотой хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно.

(d) Залруулга нь нэг этгээдийн нэгээс дээш бүртгэлд хамаарч байвал алдаа болон түүнийг залруулах хүсэлт нь бүртгэл бүрийн хувьд ижил бөгөөд хүсэлтэд холбогдох бүх бүртгэлийн дугааруудыг заасан



бол нэг хүсэлт гаргахад хангалттай.

(2) [Мэдүүлэгт хамаарах алдааг залруулах] Мэдүүлэгт дугаар өгөөгүй эсхүл мэдүүлэг гаргагч эсхүл түүний төлөөлөгчид ийм дугаар мэдэгдэхгүй байгаа боловч Журамд заасны дагуу хүсэлт нь мэдүүлэгтэй адилтгагдаж байгаа тохиолдолд мэдүүлэг /мэдүүлгүүд/, эсхүл мэдүүлэг /мэдүүлгүүд/ болон бүртгэл /бүртгэлүүд/-д хамаарах алдааг залруулахад (1) дүгээр заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ.

(3) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал энэ зүйлд заасан хүсэлтийн хувьд (1), (2) дугаар заалтууд болон 8 дугаар зүйлд зааснаас өөр зүйл шаардахгүй.

(4) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдэгдсэн алдаа нь бодит алдаа мөн эсэх талаар Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл түүнд нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

(5) [Албаны гаргасан алдаа] Хэлэлцэн тохирогч талын Алба нь өөрийн гаргасан алдааг *ex-officio буюу бүрэн эрхийнхээ дагуу* эсхүл хүсэлтийн дагуу аливаа хураамжгүйгээр залруулна.

(6) [Залруулах боломжгүй алдаа] Хэлэлцэн тохирогч аливаа тал өөрийн хууль тогтоомжийн дагуу залруулах боломжгүй аливаа алдааны хувьд (1), (2) болон (5) дугаар заалтыг хэрэглэх үүрэг хүлээхгүй.

13 дугаар зүйл

Бүртгэлийн хүчинтэй байх хугацаа ба түүнийг сунгах

(1) [Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг бүрдүүлэх эсхүл түүнийг дагалдах заалт буюу бүрдэл хэсэг; Хураамж]

(а) Хэлэлцэн тохирогч аливаа тал бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулахад хүсэлт гаргах болон энэ хүсэлтэд дараахь заалт эсхүл бүрдэл хэсгийн зарим эсхүл бүгдийг агуулсан байхыг шаардаж болно:

(i) Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлт;

(ii) Эзэмшигчийн нэр, хаяг;

(iii) Холбогдох бүртгэлийн дугаар;

(iv) Хэлэлцэн тохирогч тал хүсвэл тухайн бүртгэлд хамаарах мэдүүлгийн анхдагч огноо эсхүл холбогдох бүртгэл хийгдсэн огноо;

(v) Эзэмшигч нь төлөөлөгчтэй бол түүний нэр, хаяг;

(vi) Эзэмшигч нь харилцах хаягтай бол түүнийг;

(vii) Хэлэлцэн тохирогч тал бүртгэлийн хүчинтэй байх хугацааг тэмдгийн бүртгэлд орсон зөвхөн зарим бараа, үйлчилгээний хувьд сунгахыг зөвшөөрдөг бөгөөд ийм сунгалт хийх хүсэлт ирсэн тохиолдолд сунгалт



хийлгэх Нийцдийн ангиллын дагуу ангилсан бараа, үйлчилгээний нэрс эсхүл сунгалт хийлгэхгүй бараа, үйлчилгээний нэрс. Ингэхдээ дурдсан Ангиллын дарааллын дагуу жагсаасан бүлэг бүрийн өмнө холбогдох ангийн дугаарыг заана;

(viii) Хэлэлцэн тохирогч тал бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг эзэмшигч эсхүл түүний төлөөлөгчөөс өөр этгээд гаргахыг зөвшөөрдөг бол түүний нэр, хаяг.

(b) Хэлэлцэн тохирогч Талууд бүртгэлийн хүчинтэй хугацааг сунгуулах тухай хүсэлттэй холбоотой хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно. Бүртгэлийн үндсэн эсхүл сунгуулсан хугацаанд хураамж төлөгдсөн бол дээрх хугацааны хувьд бүртгэлийг хүчинтэй байлгах зорилгоор нэмэлт хураамж шаардахгүй. Энэ дэд хэсгийн зорилгоор тэмдгийн ашиглалтын талаарх мэдэгдэл болон нотолгоо гаргахтай холбоотой хураамжийг бүртгэлийг хүчинтэй байлгах хураамжид тооцохгүй бөгөөд энэ хэсгийн заалт үүнд хамаарахгүй.

(c) Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд Албанд бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргах. (b) дэд хэсэгт заасан хураамжийг төлөхийг шаардаж болно. Дээрх хугацаа нь Журмаар тогтоосон хамгийн бага хугацаанд нийцсэн байна.

(2) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа тал бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлттэй холбоотойгоор (1) дүгээр заалт болон 8 дугаар зүйлд зааснаас бусад зүйлийг шаардахгүй. Тухайлбал, дараахь зүйлийг шаардаж болохгүй:

(i) Тэмдгийн аливаа илэрхийлэл эсхүл бусад тодорхойлолт;

(ii) Тэмдгийн аливаа бусад бүртгэлд тэмдэг бүртгэгдсэн эсхүл тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгасан талаарх нотолгоо гаргаж өгөхийг;

(iii) Тэмдгийн ашиглалттай холбоотой мэдэгдэл, нотолгоо гаргаж өгөхийг;

(3) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч аливаа тал бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтэд агуулагдах заалт эсхүл бүрдэл хэсгийн үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад Албанд нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

(4) [Мөн чанарын шүүлт хийхийг хориглох] Хэлэлцэн тохирогч аливаа талын Алба бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад тухайн бүртгэлийн хувьд мөн чанарын шүүлт хийхгүй.

(5) [Бүртгэлийн хүчинтэй байх хугацаа] Бүртгэлийн хүчинтэй байх үндсэн хугацаа болон сунгалт бүрийн хугацаа нь 10 жил байна.

**14 дүгээр зүйл****Хугацаа баримтлах шаардлагыг хангаагүй
тохиолдолд үзүүлэх хөнгөлөлт**

(1) [Хугацаа дуусахаас өмнө үзүүлэх хөнгөлөлт] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэг эсхүл бүртгэлтэй холбоотой Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон хугацааг сунгуулах тухай хүсэлтийг энэхүү хугацаа дуусахаас өмнө Албанд ирүүлсэн бол дээрх хугацааг сунгаж болно.

(2) [Хугацаа дууссаны дараа үзүүлэх хөнгөлөлт] Хэлэлцэн тохирогч аливаа тал мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээд мэдүүлэг эсхүл бүртгэлтэй холбоотой Албаны ажиллагаанд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон хугацааг (цаашид "холбогдох хугацаа" гэх) баримтлаагүй бөгөөд энэ хугацааг сунгуулах тухай Албанд хүсэлт гаргасан бол Журмаар тогтоосон шаардлагад нийцүүлэн дор дурдсанаас нэг буюу түүнээс дээш хөнгөлөлтийг үзүүлнэ.

(i) Холбогдох хугацааг Журмаар тогтоосон хугацаагаар сунгах;

(ii) Мэдүүлэг эсхүл бүртгэлийг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх;

(iii) Хэлэлцэн тохирогч талын сонголтоор тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авсан хэдий ч эсхүл санаатай бус үйлдлийн улмаас холбогдох хугацааг баримтлаагүй гэж Алба үзвэл мэдүүлэг эсхүл бүртгэлд хамаарах мэдүүлэг гаргагч, эзэмшигч эсхүл бусад сонирхогч этгээдийн эрхийг сэргээх.

(3) [Хамаарахгүй зүйл] Хэлэлцэн тохирогч Талууд Журмаар тогтоосон хамаарахгүй зүйлийн хувьд (2) дугаар заалтад заасан аль нэг хөнгөлөлтийг үзүүлэх үүрэг хүлээхгүй.

(4) [Хураамж] Хэлэлцэн тохирогч Талууд (1), (2) дугаар заалтад заасан аливаа хөнгөлөлт эдлэхтэй холбоотой хураамж төлсөн байхыг шаардаж болно.

(5) [Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн тохирогч Талууд (2) дугаар заалтад заасан аливаа хөнгөлөлтийн хувьд энэ Зүйл болон 8 дугаар Зүйлд зааснаас өөр зүйлийг шаардахгүй.

15 дугаар зүйл**Парисын Конвенцийг дагаж мөрдөх үүрэг**

Хэлэлцэн тохирогч Талууд Парисын Конвенцийн тэмдэгт хамаарах заалтуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.



16 дугаар зүйл
Үйлчилгээний тэмдэг

Хэлэлцэн тохиролцогч Талууд үйлчилгээний тэмдгийг бүртгүүлэх бөгөөд эдгээр тэмдгүүдэд Парисын Конвенцийн барааны тэмдгийн талаарх холбогдох заалтуудыг хэрэглэнэ.

17 дугаар зүйл
Лиценз бүртгүүлэх тухай хүсэлт

(1) [Лиценз бүртгүүлэх тухай хүсэлтэд хамаарах шаардлага] Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу лицензийг Албанд бүртгүүлэхийг шаарддаг бол Хэлэлцэн тохирогч тал нь бүртгүүлэх тухай хүсэлтэд дараахь шаардлагыг тавьж болно. Үүнд:

- (i) Журмаар тогтоосон шаардлагын дагуу гаргасан байх ба
- (ii) Журмаар тогтоосон нэмэлт баримт бичгийг хавсаргасан байх.

(2) [Хураамж] Хэлэлцэн тохирогч Талууд лиценз бүртгүүлэхтэй холбоотой хураамжийг Албанд төлсөн байхыг шаардаж болно.

(3) [Хэд хэдэн бүртгэлд хамаарах нэг хүсэлт] Лиценз нь нэгээс дээш бүртгэлд хамаарч байвал эзэмшигч ба лиценз авагч нь бүртгэл бүрийн хувьд ижил бөгөөд хүсэлтэд холбогдох бүх бүртгэлийн дугаарууд болон Журамд заасны дагуу лицензийн хамрах хүрээг заасан бол нэг хүсэлт гаргахад хангалттай.

(4) [Бусад шаардлагуудыг хориглох]

(a) Хэлэлцэн тохирогч Талууд Албанд лицензийг бүртгүүлэхтэй холбоотойгоор (1)-(3) дугаар заалт болон 8 дугаар зүйлд зааснаас өөр зүйл шаардаж болохгүй. Тухайлбал:

- (i) Лицензийн объект болох тэмдгийн бүртгэлийн гэрчилгээ;
- (ii) Лицензийн гэрээ эсхүл түүний орчуулга;
- (iii) Лицензийн гэрээний санхүүгийн нөхцөл.

(b) Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу тэмдгийн бүртгэлд лицензийг бүртгэхээс өөр зорилгоор мэдээлэл дэлгэх аливаа үүргийн хувьд (a) дэд хэсэг хамаарахгүй.

(5) [Нотолгоо] Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлт эсхүл Журамд дурдсан аливаа баримт бичигт агуулагдах заалт эсхүл бүрдэл хэсгийн үнэн зөв байдлын хувьд Албанд үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл түүнд нотолгоо гаргаж өгөхийг шаардаж болно.

(6) [Мэдүүлэгт хамаарах хүсэлт] Хэлэлцэн тохирогч талын хууль

тогтоомжоор мэдүүлгийн лицензийг бүртгүүлэхийг шаарддаг бол ийм хүсэлтийн хувьд (1)-(5) дугаар заалтуудыг *mutatis mutandis* хэрэглэнэ.

18 дугаар зүйл

Лицензийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгуулах тухай хүсэлт

(1) [Хүсэлтэд хамаарах шаардлага] Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу лицензийг Албанд бүртгүүлэхийг шаарддаг бол Хэлэлцэн тохирогч тал нь лицензийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгуулах тухай хүсэлтэд дараахь шаардлагыг тавьж болно. Үүнд:

- (iii) Журмаар тогтоосон шаардлагын дагуу гаргасан байх ба
- (iv) Журмаар тогтоосон нэмэлт баримт бичгийг хавсаргасан байх.

(2) [Бусад шаардлага] Лицензийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгуулах тухай хүсэлтийн хувьд 17 дугаар зүйлийн (2)-(6) дугаар заалтыг *mutatis mutandis* хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

Лицензийг бүртгүүлээгүйгээс үүсэн гарах үр дагавар

(1) [Тэмдгийн бүртгэлийн хүчин төгөлдөр байдал ба тэмдгийн хамгаалалт] Албанд буюу Хэлэлцэн тохирогч талын бусад эрх бүхий байгууллагад лицензийг бүртгүүлээгүй нь лицензийн объект болох тэмдгийн бүртгэлийн хүчин төгөлдөр байдал эсхүл тэмдгийн хамгаалалтад нөлөөлөхгүй.

(2) [Лиценз авагчийн зарим эрх] Лицензийн бүртгэл нь лицензийн объект болох тэмдгийн эрх зөрчигдсөнтэй холбоотойгоор эзэмшигчийн санаачлагаар эхлүүлсэн ажиллагаанд нэгдэх эсхүл ийм ажиллагаагаар дамжуулан тухайн тэмдгийн эрх зөрчигдсөнөөс учирсан хохирлын нөхөн төлбөрөөс хүртэх зэрэг Хэлэлцэн тохирогч талын лиценз авагчид олгосон эрхийг эдлэх нөхцөл байхаар шаардахгүй байж болно.

(3) [Лицензийн бүртгэлгүйгээр тэмдгийг ашиглах] Лицензийн бүртгэл нь лиценз авагч тэмдгийг ашиглах нь тэмдгийн эзэмшигч тэмдгийг эзэмших, хүчинтэй байлгах болон хамгаалахтай холбоотойгоор ашиглахтай адилтган үзэх нөхцөл байхаар шаардахгүй байж болно.

20 дугаар зүйл

Лицензийн талаарх заалт

Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор тэмдэг нь лицензээр



ашиглагдаж байгааг заахыг шаарддаг бол энэхүү шаардлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй нь лицензийн объект болох тэмдгийн бүртгэлийн хүчин төгөлдөр байдал эсхүл тэмдгийн хамгаалалтад нөлөөлөхгүй бөгөөд 19 дүгээр зүйлийн (3) дугаар заалтын хэрэглээг хөндөхгүй.

21 дүгээр зүйл

Татгалзах тохиолдолд гаргах тайлбар

Алба нь 3 дугаар зүйлд заасан мэдүүлэг эсхүл 7, 10-14, 17 болон 18 дугаар зүйлд заасан хүсэлтийг мэдүүлэг гаргагч эсхүл хүсэлт гаргагчид зохих хугацаанд татгалзалтай холбогдуулан тайлбар гаргах боломж олголгүйгээр бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзаж болохгүй. 14 дүгээр зүйлийн хувьд хөнгөлөлт үзүүлэхийг хүссэн этгээд өмнө нь шийдвэр гаргахад үндэслэсэн асуудлаар тайлбар гаргах боломжийг эдэлсэн бол түүнд тайлбар хийх боломж олгохыг аливаа Албанаас шаардахгүй.

22 дугаар зүйл

Журам

(1) [Агуулга]

(a) Энэхүү Гэрээний хавсралт болох Журам дараахь зүйлд хамаарах зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

(i) Энэхүү Гэрээнд "Журмаар тогтоосон" гэж тусгайлан заасан асуудлууд;

(ii) Энэхүү Гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа зүйлүүд;

(iii) Зохион байгуулалтын шинжтэй аливаа шаардлага, асуудал эсхүл үйл ажиллагаа.

(b) Журам нь мөн Олон улсын загварчилсан маягтуудыг агуулна.

(2) [Журамд өөрчлөлт оруулах] Журамд аливаа өөрчлөлт оруулахад

(3) дугаар заалтыг харгалзан нийт өгсөн саналын дөрөвний гуравтай тэнцэх санал шаардагдана.

(3) [Нэгдмэл саналын шаардлага]

(a) Журамд зөвхөн нэгдмэл саналын үндсэн дээр өөрчлөлт оруулж болох Журмын заалтуудыг тусгайлан зааж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу Журамд тусгайлан заасан заалтуудад нэмэлт эсхүл хасалт хийх үр дагавар бүхий аливаа өөрчлөлтийг Журамд оруулахад нэгдмэл санал шаардагдана.



(с) Санал нэгдсэн эсэхийг тогтооход зөвхөн санал хураалтаар өгсөн саналыг харгалзан үзнэ. Түдгэлзсэнийг саналд тооцохгүй.

(4) [Гэрээ болон Журам хоорондын зөрчилдөөн] Энэхүү Гэрээ болон Журмын заалтууд хоорондоо зөрчилдөх тохиолдолд Гэрээний Заалтуудыг дагаж мөрдөнө.

23 дугаар зүйл

Чуулган

(1) [Бүрэлдэхүүн]

(a) Хэлэлцэн тохирогч Талууд Чуулгантай байна

(b) Хэлэлцэн тохирогч тал бүр Чуулганд нэг төлөөлөгчтэй байх бөгөөд тэр нь орлогч, зөвлөх болон шинжээчтэй байж болно. Төлөөлөгч бүр зөвхөн нэг Хэлэлцэн тохирогч талыг төлөөлж болно.

(2) [Үүрэг] Чуулган нь дараахь үүрэгтэй байна. Үүнд:

(i) Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг хариуцах;

(ii) Олон улсын загварчилсан маягтуудад болон Журамд өөрчлөлт оруулах;

(iii) (ii)-т хамаарах өөрчлөлт бүрийг хэрэглэх огноотой холбоотой нөхцлийг тодорхойлох;

(iv) Энэхүү Гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үүргийг гүйцэтгэх.

(3) [Чуулганыг хүчин төгөлдөрт тооцох]

(a) Чуулганы гишүүн болох Улсын тэн хагас бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөрт тооцно.

(b) Чуулган нь (a) дэд хэсгийг үл харгалзан аль нэгэн хуралдаанд Чуулганы гишүүд болох Улсуудын төлөөлөгчдийн тоо нь тэн хагасаас бага боловч Чуулганы гишүүд болох Улсуудын гуравны нэгтэй тэнцүү эсхүл түүнээс илүү байвал шийдвэр гаргаж болох бөгөөд Чуулганы өөрийнх нь үйл ажиллагааны дүрэмд хамаарахаас бусад бүх шийдвэр нь гагцхүү дор дурдсан нөхцөл бүрэлдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь дурдсан шийдвэрүүдийг хуралдаанд оролцоогүй Чуулганы гишүүн болох Улсуудад илгээх бөгөөд энэхүү шийдвэрийг илгээснээс хойш 3 сарын дотор түүнд санал өгөх эсэх эсхүл түдгэлзэж байгаа тухайгаа бичгээр мэдэгдэхийг уриална. Энэ хугацаа дуусах үед санал өгсөн эсхүл түдгэлзсэн гишүүдийн тоо нь хуралдааныг хүчин төгөлдөрт тооцогдоход хүрэлцэхгүй байсан гишүүдийн тоонд хүрч байгаа бөгөөд тухайн үед хүчин төгөлдөр болгоход шаардлагатай олонхи болох тоо нь хэвээрээ байгаа бол шийдвэрийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

(4) [Чуулганаар шийдвэр гаргах]

(a) Чуулган нь өөрийн шийдвэрийг зөвшилцлийн үндсэн дээр гаргахыг эрмэлзэнэ.

(b) Зөвшилцлийн үндсэн дээр шийдвэр гаргах боломжгүй бол хэлэлцэж буй асуудлаарх шийдвэрийг санал хураалтын үндсэн дээр гаргана. Ингэхдээ:

(i) Хэлэлцэн тохирогч тал болох Улс бүр нэг саналын эрхтэй байх бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө; мөн

(ii) Хэлэлцэн тохирогч тал болох Засгийн газар хоорондын байгууллага энэхүү Гэрээний оролцогч болох өөрийн гишүүн улсуудын тоотой тэнцүү саналын эрхтэйгээр тэдгээрийн нэрийн өмнөөс санал хураалтад оролцож болно. Засгийн газар хоорондын байгууллага түүний гишүүн аливаа улс нь санал хураалтад оролцох эрхээ эдэлж байгаа тохиолдолд тухайн санал хураалтад оролцохгүй бөгөөд энэ нь эсрэгээрээ байх тохиолдолд мөн хамаарна. Үүнээс гадна энэхүү Гэрээний оролцогч болох Засгийн газар хоорондын байгууллагын нэг гишүүн улс нь санал хураалтад оролцож буй өөр Засгийн газар хоорондын байгууллагын гишүүн улс бол санал хураалтад оролцохгүй.

(5) [Олонхи]

(a) 22 дугаар зүйлийн (2), (3) дугаар заалтыг харгалзан Чуулган шийдвэр гаргахад өгсөн нийт саналын гуравны хоёртой тэнцэх санал шаардагдана.

(b) Шаардагдах олонхи бүрдсэн эсэхийг тогтооход зөвхөн санал хураалтаар өгсөн саналыг харгалзан үзнэ. Түдгэлзсэнийг саналд тооцохгүй.

(6) [Хуралдаан] Чуулган нь ээлжит хуралдаанаа онцгой нөхцөл байдал гараагүй тохиолдолд Ерөнхий захирлын зарласнаар Байгууллагын Ерөнхий Чуулган хуралдах үеэр нэг газарт хийнэ.

(7) [Үйл ажиллагааны дүрэм] Чуулган ээлжит бус хуралдаан зарлах зэрэг өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

24 дүгээр зүйл
Олон улсын товчоо

(1) [Зохион байгуулалтын шинжтэй үүрэг]

(a) Олон улсын товчоо нь энэхүү Гэрээнд хамаарах зохион байгуулалтын шинжтэй үүргийг гүйцэтгэнэ.

(b) Тухайлбал, Олон улсын товчоо нь хурлын бэлтгэлийг зохион байгуулах ба Чуулганы болон Чуулганаас байгуулж болох шинжээчдийн хороо болон ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.



(2) [Чуулганы хуралдаанаас бусад хурлууд] Ерөнхий захирал Чуулганаас байгуулагдсан аливаа хороо болон ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулна.

(3) [Чуулган болон бусад хуралд Олон улсын товчооны гүйцэтгэх үүрэг]

(a) Ерөнхий захирал болон Ерөнхий захирлын томилсон этгээдүүд Чуулганы бүх хуралдаан, Чуулганаас байгуулсан хороо болон ажлын хэсгийн бүх хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

(b) Ерөнхий захирал эсхүл Ерөнхий захирлын томилсон ажилтан нь Чуулган, (a) дэд хэсэгт заасан хороо болон ажлын хэсгийн *ex-officio* /эрх бүхий/ нарийн бичгийн дарга байна.

(4) [Бага хурал]

(a) Олон улсын товчоо нь Чуулганаас өгсөн чиглэлийн дагуу аливаа хяналтын бага хурлын бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ.

(b) Олон улсын товчоо нь дээр дурдсан бэлтгэл ажилтай холбоотой асуудлаар Байгууллагын гишүүн Улс, Засгийн газар хоорондын болон олон улсын ба үндэсний төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон Ерөнхий захирлын томилсон этгээд хяналтын бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцоно.

(5) [Бусад үүрэг] Олон улсын товчоо нь энэхүү Гэрээтэй холбоотойгоор түүнд хариуцуулсан бусад үүргийг гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл

Хянах эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах

Энэхүү Гэрээг зөвхөн дипломат бага хурлаар хянах эсхүл түүнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Аливаа дипломат бага хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг Чуулган гаргана.

26 дугаар зүйл

Гэрээнд оролцогч Тал болох

(1) [Гэрээнд оролцох эрх] Дараахь субъектууд (2), (3) дугаар заалт, мөн 28 дугаар зүйлийн (1), (3) дугаар заалтыг харгалзан Гэрээнд гарын үсэг зурж, оролцогч тал болж болно. Үүнд:

(i) Албанд нь тэмдэг бүртгэгдэх боломжтой, Байгууллагын аливаа гишүүн Улс;

(ii) Засгийн газар хоорондын байгууллагыг байгуулах гэрээ нь хамаарах нутаг дэвсгэрт, түүний бүх Гишүүн Улсуудад эсхүл холбогдох



мэдүүлгийн зорилгоор нэр заагдсан түүний Гишүүн Улсуудад хүчинтэй байх тэмдэг бүртгэгдэх боломжтой Алба бүхий аливаа Засгийн газар хоорондын байгууллага, Ингэхдээ тухайн Засгийн газар хоорондын байгууллагын бүх гишүүн Улс нь Байгууллагын гишүүн байна;

(iii) Зөвхөн Байгууллагын гишүүн болох аль нэг тусгайлан заасан Улсын Албаар дамжуулан бүртгүүлэх замаар тэмдэг бүртгэх боломжтой Байгууллагын гишүүн Улс;

(iv) Зөвхөн аль нэг Засгийн газар хоорондын байгууллагын Албаар дамжуулан бүртгүүлэх замаар тэмдэг бүртгэх боломжтой тухайн Засгийн газар хоорондын байгууллагын гишүүн болох Байгууллагын гишүүн Улс;

(v) Зөвхөн Байгууллагын гишүүн болох хэд хэдэн гишүүн Улсуудын нэгдсэн Албаар дамжуулан бүртгүүлэх замаар тэмдэг бүртгэх боломжтой Байгууллагын гишүүн Улс;

(2) [Соёрхон батлах буюу нэгдэн орох] (1) дүгээр заалтад заасан аливаа этгээд дараахь баримт бичгийг хадгалуулж болно. Үүнд:

(i) Гэрээнд гарын үсэг зурсан бол соёрхон баталсан тухай баримт бичиг;

(ii) Гэрээнд гарын үсэг зураагүй бол нэгдэн орсон тухай баримт бичиг.

(3) [Хадгалуулахаар өгсөн хүчинтэй огноо] Дараахь огноог соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн хүчинтэй огноонд тооцно:

(i) (1)(i)-д заасан Улсын хувьд тухайн Улс холбогдох баримт бичгээ хадгалуулахаар ирүүлсэн огноо;

(ii) Засгийн газар хоорондын байгууллагын хувьд тухайн Засгийн газар хоорондын байгууллага холбогдох баримт бичгээ хадгалуулахаар ирүүлсэн огноо;

(iii) (1)(iii)-т заасан Улсын хувьд тухайн Улс холбогдох баримт бичгээ болон тусгайлан заагдсан Улс холбогдох баримт бичгээ хадгалуулахаар ирүүлсэн огноо;

(iv) (1)(iv)-т заасан Улсын хувьд энэ хэсгийн (ii)-т хамаарах огноо;

(v) (1)(v)-д заасан Улсуудын бүлгийн гишүүн Улсын хувьд бүлгийн гишүүн бүх Улс баримт бичгээ хадгалуулахаар ирүүлсэн огноо.

27 дугаар зүйл

1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай

Гэрээ ба энэхүү Гэрээг хэрэглэх

(1) [Энэхүү Гэрээ болон 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээний аль алиных нь оролцогч болох Хэлэлцэн тохирогч Талуудын харилцаа] Энэхүү Гэрээ болон 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээний аль алиных нь оролцогч болох Хэлэлцэн тохирогч Талуудын харилцааг зөвхөн энэ Гэрээгээр зохицуулна.



(2) [Энэхүү Гэрээний Хэлэлцэн тохирогч Талууд болон энэхүү Гэрээний оролцогч бус 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээний Хэлэлцэн тохирогч Талуудын харилцаа] Энэхүү Гэрээ болон 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээний аль алиных нь Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Гэрээний оролцогч бус 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээний Хэлэлцэн тохирогч Талтай харилцахдаа 1994 оны Барааны тэмдгийн хуулийн тухай Гэрээг хэрэглэнэ.

28 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох;

Соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичиг хүчинтэй болох огноо

(1) [Хэрэгсэн үзэх баримт бичиг] Энэ зүйлийн зорилгоор 26 дугаар зүйлийн (1)-д заасан этгээдийн хадгалуулахаар ирүүлсэн болон 26 дугаар зүйлийн (3)-т заасан хүчинтэй болох огноо бүхий соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хэрэгсэн үзнэ.

(2) [Гэрээ хүчин төгөлдөр болох] Энэхүү Гэрээ нь 26 дугаар зүйлийн (1)(ii) хэсэгт заасан арван Улс эсхүл Засгийн газар хоорондын байгууллага соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

(3) [Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ирүүлсэн соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичиг хүчин төгөлдөр болох] Энэхүү Гэрээ нь (2) дахь хэсэгт үл хамаарах аливаа этгээдийн хувьд соёрхон баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Тайлбар

(1) [Тэмдгийн тусгай төрлүүд] Аливаа Улс эсхүл Засгийн газар хоорондын байгууллага нь 2(1) ба 2(a) дугаар зүйлийг үл харгалзан тайлбар хийх замаар 3(1), 5, 7, 8(5), 11 болон 13 дугаар зүйлүүдийн аль ч заалтыг нэгдсэн, хамгаалалтын эсхүл үүсмэл тэмдгүүдэд хэрэглэх үүрэг хүлээхгүй тухай мэдэгдэж болно. Тайлбартаа дээр дурцсан заалтуудаас ийм тайлбар нь хамаарах заалтуудыг тусгайлан заана.

(2) [Хэд хэдэн ангилалд хамаарах бүртгэл] Энэхүү Гэрээг батлах үед өөрийн хууль тогтоомжоор барааны болон үйлчилгээний хэд хэдэн ангид тусад нь бүртгэл хийдэг аливаа Улс эсхүл засгийн газар хоорондын байгууллага нь энэхүү Гэрээнд нэгдэн орохдоо 6 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэх үүрэг хүлээхгүй тухай тайлбар хийх замаар мэдэгдэж болно.

(3) [Хүчинтэй байх хугацааг сунгахтай холбоотой мөн чанарын шүүлт] Аливаа Улс эсхүл Засгийн газар хоорондын байгууллага нь 13(4) дугаар зүйлийг үл харгалзан тайлбар хийх замаар үйлчилгээнд хамаарах бүртгэлийн хүчинтэй байх хугацааг анх удаа сунгуулахад Алба тухайн бүртгэлд мөн чанарын шүүлт хийж болох тухай мэдэгдэж болно. Ингэхдээ мөн чанарын шүүлт нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө үйлчилгээний тэмдэг бүртгэх боломж олгосон тухайн Улс эсхүл байгууллагын хууль тогтоомж хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын хугацаанд гаргасан мэдүүлэгт үндэслэсэн давхардмал олон бүртгэлийг устгах зорилгоор хязгаарлагдана.

(4) [Лиценз авагчийн зарим эрх] Аливаа Улс эсхүл засгийн газар хоорондын байгууллага нь 19(2) дугаар зүйлийг үл харгалзан тайлбар хийх замаар лицензийн бүртгэл нь лицензийн объект болох тэмдгийн эрх зөрчигдсөнтэй холбоотойгоор эзэмшигчийн санаачлагаар эхлүүлсэн ажиллагаанд нэгдэх эсхүл ийм ажиллагаагаар дамжуулан тухайн тэмдгийн эрх зөрчигдсөнөөс учирсан хохирлын нөхөн төлбөрөөс авах зэрэг Хэлэлцэн тохирогч талын лиценз авагчид олгосон эрхийг эдлэх нөхцөл байхаар шаарддаг тухай мэдэгдэж болно.

(5) [Зарим тайлбар хийх арга] (1), (2), (3) эсхүл (4) дүгээр заалтуудын дагуу хийгдэх аливаа тайлбарыг холбогдох Улс эсхүл засгийн газар хоорондын байгууллага энэхүү Гэрээг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичигтээ дагалдуулан мэдэгдэл болгон хавсаргана.

(6) [Тайлбарыг эргүүлэн татах] (1), (2), (3) эсхүл (4) дүгээр заалтад заасны дагуу хийгдсэн аливаа тайлбарыг дурын хугацаанд эргүүлэн татаж болно.

(7) [Бусад тайлбар хийхийг хориглох] (1), (2), (3) ба (4) дүгээр заалтаар зөвшөөрөгдсөнөөс бусад тайлбарыг энэхүү Гэрээнд хийхийг хориглоно.

*30 дугаар зүйл.
Гэрээг цуцлах*

(1) [Мэдэгдэл] Хэлэлцэн тохирогч аливаа Тал Ерөнхий захиралд мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү Гэрээг цуцалж болно.

(2) [Хүчинтэй болох огноо] Ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа цуцлалт хүчинтэй болно. Цуцлалт нь дээрх нэг жилийн хугацаанд хянан шийдвэрлэх шатанд байгаа аливаа мэдүүлэг эсхүл бүртгэгдсэн тэмдэгт энэхүү Гэрээг хэрэглэх явдалд нөлөөлөхгүй. Ингэхдээ Гэрээг цуцалж буй Хэлэлцэн тохирогч Тал нь дээрх хугацаа дуусмагц энэхүү бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах үеэс эхлэн энэхүү Гэрээг хэрэглэхгүй байж болно.

31 дүгээр зүйл
Гэрээний хэл; Гарын үсэг зурах

(1) [Эх бичвэр; Албан ёсны бичвэр]

(a) Энэхүү Гэрээний англи, араб, хятад, франц, орос болон испани хэлээр үйлдсэн нэг эх хувь дээр гарын үсэг зурах бөгөөд бүх бичвэр нь адил хүчинтэй байна.

(b) (a) дэд хэсэгт дурдагдаагүй бөгөөд Хэлэлцэн тохирогч Талын албан ёсны хэлээр үйлдэх албан ёсны бичвэрийг Ерөнхий захирал тухайн Хэлэлцэн тохирогч Тал болон бусад аливаа сонирхогч Хэлэлцэн тохирогч Талтай зөвлөлдсөний дараа бэлтгэн гаргана.

(2) [Гарын үсэг зурах хугацаа] Энэхүү Гэрээ нь түүнийг баталснаас хойш нэг жилийн хугацаанд Байгууллагын төв байранд гарын үсэг зурахад нээлттэй байна.

32 дугаар зүйл
Эх хадгалагч

Энэхүү Гэрээний эх хувийг Ерөнхий захиралд хадгалуулна.

(Энэхүү Гэрээний албан ёсны орчуулгыг ГХЯ хариуцан гүйцэтгэсэн болно.)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах /рдчилсан Балба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жанцангийн Гөлгөөг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ворошиловын Энхболдыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратегийн тухай

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.15.3-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратегийг сайшаасугай.

2. Үндэсний стратеги болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

3. Үндэсний стратегид дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

4. Үндэсний стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн II улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар
хот

Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Халхгол, Матад, Баянтүмэн, Булган сумын нутаг дэвсгэрт гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний халдварын голомтыг устгах, тархагтыг зогсоох үйл ажиллагааны зардалд 80.6 (наян сая зургаан зуун мянган) сая төгрөг, устгасан малын нөхөн олговорт 247.3

(хоёр зуун дөчин долоон сая гурван зуун мянган) сая төгрөг, нийт 327.9 (гурван зуун хорин долоон сая есөн зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэмийг чангатган, голомтыг устгах, мал сүргийг дархлаажуулах, өвчний тархалтад тандалт судалгаа хийж гарал үүслийг тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Дорнод аймгийн Засаг дарга С.Жанлав нарт тус тус даалгасугай.

3. Шүлхий өвчний халдвар тархах эрсдэл өндөр байгааг харгалзан хорио цээр тогтоосон нутгаас малын шилжилт хөдөлгөөн хийх, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхгүй байх, баяр наадам болон олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарлах, Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгуудад зүүн аймгуудаас мал сүргийг шилжүүлэхийг нэг жилийн хугацаагаар зогсоож, халдварын голомт илрээгүй Дорнод аймгийн сумдаас зөвхөн үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, анхан шатны боловсруулалт, халдваргүйтгэл хийсэн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрсөн хэрэгцээ, зах зээлд нийлүүлж байх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Хувиргасан амьд организмыг нэвтрүүлэх хилийн боомтын тухай

Хувиргасан амьд организмын тухай хуулийн 8.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хувиргасан амьд организмыг Улаанбаатар хотын "Буянт-Ухаа" хилийн боомтоор нэвтрүүлэхээр тогтоосугай.

2. Хувиргасан амьд организмыг хилийн боомтоор нэвтрүүлэх үйл ажиллагаанд олон улсын гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд



Л.Гансүх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатар,
Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-
ны өдрийн 177 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.5-ыг үндэслэн Монгол
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн
51 дүгээр тогтоолын хавсралтад "58. Төв аймгийн Зуунмод сум дахь өвс
тэжээлийн нөөцийн салбар" гэж нэмсүгэй.

2. Мөн тогтоолын хавсралтын 53 дахь заалтын "Хөвсгөл аймгийн
Тариалан сум дахь үр тарианы нөөцийн салбар" гэснийг "Булган аймгийн
Хутаг-Өндөр сум дахь үр тарианы нөөцийн салбар" гэж өөрчилсүгэй.

3. Мөн тогтоолын хавсралтын "Нэг. Төсвөөс санхүүждэг", "Хоёр.
Аж ахуйн тооцоотой" гэснийг тус тус хассугай.

4. Шинээр байгуулагдсан улсын нөөцийн салбарт шаардагдах
хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ

авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар
хот

Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын аж ахуйн нэгжтэй улс төр, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техник, соёл, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах асуудлыг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай уялдуулан зохицуулж байх зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

1.1. Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотой, хөгжлийн томоохон асуудлаар яриа хэлэлцээ хийхдээ гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулж байх;

1.2. Монгол Улс болон Засгийн газрыг төлөөлөн олон улсын хуралд оролцох төлөөлөгчдөд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар эрхийн үнэмлэхийг хугацаанд нь олгуулж байх;

1.3. Сайд, дэд сайд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн даргын түвшинд хэрэгжүүлсэн айлчлалын дүн, тохиролцсон арга хэмжээний талаархи мэдээллийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлж байх;

1.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын түвшинд хэрэгжүүлэх айлчлал, арга хэмжээний талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, илтгэх хуудсыг тухай бүр ирүүлж байх;

1.5. Сум, дүүргийн Засаг даргын түвшинд хэрэгжих гадаад айлчлал, арга хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг дарга



нар удирдамж, чиглэл өгч байх;

1.6. Гадаадын ижил төрлийн байгууллагатай аливаа асуудлаар хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахдаа гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөх;

1.7. Гадаад хамтын ажиллагааны тухай мэдээллийг хагас жил тутам, тайланг жилийн эцэст гаргаж, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх.

2. Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт үүрэг болгосугай.

2.1. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудад гадаад бодлого, үйл ажиллагааны талаархи мэдээллийг хагас жил тутамд хүргүүлж байх;

2.2. Монгол Улсаас гадаад оронд суугаа болон гадаад орноос Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газраас ирүүлж байгаа гадаад харилцаатай холбоотой шуурхай мэдээллийг холбогдох байгууллагад цаг алдалгүй хүргүүлж байх;

2.3. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын гадаад харилцааны асуудал хариуцсан нэгжийн ажилтан нарт зориулж гадаад харилцаанд баримтлах бодлого, чиглэл, дипломат ёслол, яриа хэлэлцээ явуулах арга зэрэг асуудлаар жил бүрийн I улиралд багтаан сургалт, семинар зохион байгуулж байх;

2.4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны жилийн тайланг нэгтгэн Монгол Улсын гадаад харилцааны нэгдсэн тайлан гаргаж, дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт санал, дүгнэлтийн хамт танилцуулж байх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гадаад хамтын ажиллагааны зохицуулалтыг сайжруулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 321 дүгээр тогтоолыг хүчингүйд болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБУЛД

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medecele@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Үесийн Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас-329487